

НҮҮДЛИЙН ХИЙГЭЭД СУУРИН СОЁЛ ИРГЭНШЛИЙН ЯЛГАА, ХАРИЛЦАН ХАМААРЛЫН АСУУДАЛД

Ж.Баясах *

Өрнөдийн түүхч, улс төр судлаач Арнольд Тойнби, Самуэль Хантингтон, З.Бжежинский зэрэг судлаачид өөрсдийн зохиол бүтээлдээ дэлхийд олон соёл иргэншил зэрэгцэн оршин байдаг, тэдгээрийн дотроос өвөрмөц давтагдашгүй байдал, онцлогтой нь өрнөдийн, лалын, хиндүгийн, кунзын, японы, үнэн алдартны буюу оросын хэмээн тоочиж бичсэн атлаа нүүдлийн соёл иргэншлийн талаар дурьдсан нь үгүй ажээ. Зөвхөн З.Бжежинский л хятад кунзийн соёл иргэншлийг тоочин бичих зуураа Монголын эзэнт улс Хятадыг эрхшээлдээ оруулж соёл иргэншлийнх нь төлөвшилтөд нөлөө үзүүлж байсан хэмээн цухас дурьдсан байдаг. Ерөөс өнөөг хүртэл Л.Н.Гумилёв авгайгаас өөр эрдэмтэн нүүдлийн соёл иргэншлийн нөлөө, онцлогийг гарган судалж үнэлээгүй л байна. Монгол улс нь түүхэндээ өнөөг хүртэл хоёр их улс, хоёр их соёл иргэншил-үнэн алдартан хийгээд кунзийн гэх буюу Орос хийгээд Хятадын соёл иргэншлийн дунд оршин тогтносоор ирсэн. Манай хоёр хөрш улсын соёл иргэншил бол хоёул суурин газрын боловч өөр хоорондоо ялгаатай соёл иргэншил юм. Түүхэн хөгжлийн явцад дэлхийн энэ 2 том соёл иргэншлийн нөлөө манай улсад байсаар ирсэн. Өдгөө Монгол улс бусад суурин соёл иргэншлийн нөлөөнд орж байгаа бөгөөд тэдгээр нь Япон, Солонгос, Өрнөдийн соёл иргэншил болно. Ийм байдал дор бид өөрийн гэсэн соёл иргэншилтэй улс мөн үү, эсхүл аль нэг соёл иргэншлийн хавсарга уу гэдгийг тогтоохын тулд энэхүү тулгамдсан сэдвээр өөрийн бодол санааг нэмэрлэхийг оролдсон болно.

Суурин хийгээд нүүдлийн соёл иргэншил

Миний үзэхэд дэлхийд хоёр том соёл иргэншил байна. Тэр нь нүүдлийн хийгээд суурин газрын соёл иргэншил юм. Өнөөдөр дэлхийн улс үндэстний 10 хувь нь нүүдлийн

* МУИС, ОУХС-ийн тэргүүлэх профессор, доктор(Sc.D)

амьдралаар аж төрдөг хэмээх бөгөөд ойролцоогоор дэлхийн нийт хүн ам 6 тэрбум бол түүний 600 сая нь нүүдлийн амьдралтай, нүүдлийн соёл иргэншлээр аж төрж байна гэсэн үг. Харин дэлхийн хүн амын үлдэх дийлэнх улс үндэстнүүд суурин амьдралтай, суурин соёл иргэншилтэй байна хэмээн үзэж болох талтай. Суурин соёл иргэншил нь шашин хийгээд үндэсний улсын гэсэн тодотголтой байж болно. Тухайлбал, загалмайтны, лалын, кунзын, хиндүгийн, үнэн алдартны, жүдийн хэмээн шашнаар нь тодотгол хийсэн соёл иргэншлийн ангилал байж болно. Эсхүл Америкийн, Европын, Хятадын, Энэтхэгийн, Арабын, Оросын, Индианы, Солонгосын, Японы, Монголын соёл иргэншил гэж тив хийгээд улсаар нь, мөн үндэстнээр нь ангилан нэрийдэж болох мэт.

Ийнхүү хүн төрөлхтний соёл иргэншлийг зөвхөн суурин хийгээд нүүдлийн хэмээн хоёр ангилахын цаад учир нь эрхэлдэг үндсэн хоёр аж ахуй болох газар тариалан, мал аж ахуй дээр тулгуурлан авч үзсэнтэй холбоотой. Уламжлалт эл аж ахуйн хэлбэрээс улбаалан зарим нь суурин амьдарч газар тариалан эрхлэхэд нөгөө хэсэг улс нь мал аж ахуйгаа авч явахын тулд нүүдлийн маягаар аж төрнө. Энэ аж ахуйн хуваарь хэдэн мянган жилийн тэртээгээс тухайн улс, үндэстэн, нийгэмд бий болж, тэдгээр нь аж ахуйн уламжлалт хэлбэрээ дагаж өөрийн соёл түүх юугаан бүтээж иржээ.

Соёл иргэншлийн хэв маягийг эрхэлж буй аж ахуй нь тогтоож өгдөг. Харин аль тив, аль бүс нутагт ямар аж ахуйтай байхыг зөвхөн байгаль, цаг агаар нь тодорхойлдог гэж үзвэл байгаль, дэлхий тухайн үндэстнийг ямар соёл иргэншилтэй байхыг мөн зааж залсан байна хэмээн үзүүштэй. Иймээс байгаль, цаг агаарын нөлөөгөөр газар тариалан эрхэлсэн болон мал аж ахуй дагасан суурин хийгээд нүүдлийн соёл иргэншлүүд буй болсон. Өөрөөр хэлбэл соёл иргэншлийн гол тодорхойлогч нь тив, бүс нутаг ч бус, мөн шашин ч биш, харин үндсэн аж ахуйгаа дагасан суурин хийгээд нүүдлийн амьдрал юм.

Монголын нүүдлийн соёл иргэншил

Нүүдлийн соёл иргэншил бүхий улс үндэстнүүд дотор өнө удаан жилийн түүхтэй соёл иргэншил бол Монгол туургатных юм. Монголын цаг агаар, байгальд зохицсон ганц аж ахуй бол мал аж ахуй байсан бөгөөд зөвхөн хэсэг зурвасхан газар, тухайлбал, Сэлэнгэ мөрний эрэг, Хөлөн болон Буйр нуур, Алтайн нурууны хойд биеэр эрт үеэс газар тариалан эрчимгүй хэлбэрээр эрхэлж байсан байна. Үндсэн аж ахуйгаа дагаад монголчууд өөрийн гэх онцлог бүхий нүүдлийн соёлыг бүтээсэн юм.

Нүүдэлчин монголчууд мал маллах тал дээр бусад үндэстнээс илүү их мэдлэг хуримтлуулж, малаа хаана оторлуулах, бог бод малдаа өөр өөр бэлчээр сонгох, өвс усны соргогыг хайн нүүдэллэх, тэнгэрийн сайныг од гарагаар нь шинжих зэргээр байгальтай харьцан амьдарч иржээ. Малаас гарах мах сүүг хоол хүнсэндээ, ноос ноолуур, арьс ширийг хувцас хунар, орон гэр барихад эсгий туурга, олс бүслүүр, үдүүр болгон ашиглаж ирсэн. Монгол хоол хүнсний соёл гэхэд арвин их цагаан идээн бүтээгдэхүүн гарган авдаг технологитой бөгөөд тэдгээр нь зөвхөн тоо төрлөөрөө олон төдийгүй илчлэгийн хувьд өөр өөр, цагаан идээгээ зуны улиралд дагнан хэрэглэдэг бол хүйтэн оронгуут мах, махан бүтээгдэхүүн дөмөг хэрэглэж дулаан илчээ авдгаараа онцлогтой. Монголчууд хэдэн мянган жилийн турш сууцаа улам боловсронгуй болгож ирснээр монгол гэр гэдэг өвөрмөц уран барилгын бүтээлийг буй болгож нүүж суухад амар, өвөлдөө дулаан, зундаа сэрүүхэн сууцыг бүтээсэн нь өнөө болтол гадаадын хүмүүсийн гайхлыг төрүүлж байна. Монгол хүний амьдралыг морьгүйгээр төсөөлөхийн аргагүй бөгөөд манай урд хөршийн түүх сударт Монгол улсыг “морь унаж нум сум агсагч нар” хэмээн тэмдэглэн үлдээсэн байдаг нь учиртай. Монголчууд ертөнцийн талыг эзлэхдээ мөн л морио унаж, нум сумаа агсаж байсан төдийгүй эзлэн авсан газартаа морин өртөө замыг байгуулсан нь тухайн үедээ өнөөгийн буухиа шуудан, интернетийн холбоог үүдснээс өөрцгүй том дэвшил байв. Мориныхоо сүүлээр гайхам сайхан эгшиглүүн хөгжмийн зэмсэг бүтээсэн нь морин хуур бөгөөд өдгөө хүртэл чинагшид ч ертөнцийн чихний чимэг байх болно. Морин хуурын эгшгэнд хүн зон олон уяраад зогсохгүй ботгоо голсон ингэ хүртэл нулимс унаган хайлж, төлөө уяран хөхүүлдэг нь гадаадынхны гайхлыг төрүүлдэг бас учиртай. Монгол хүний найраг шүлэг, үлгэр домог, тоглоом наадам бүгд амьдралыг нь тэтгэгч малтай холбоотой. Арабын хойгоор нутаглагч бедуйнууд нүүдэллэн амьдрахдаа тэмээн жингийнхээ явдал, алхаанд тохируулан өөрийн араб үсэг бичиг хийгээд ардын дууг зохиосон гэдэг бол монголчууд малаа билчээх тал хөндийтэйгээ адил уртын дуу хэмээх өвөрмөц нэгэн хэмнэл айзамтай дуу хуурыг бүтээсэн ард түмэн. Монголчууд ийн өөрийн соёлыг өвөрмөц байдлаар буюу таван хошуу малдаа, байгаль дэлхийдээ шүтсэн хэлбэрээр бүтээсэн бөлгөө.

Монголчууд бид дэлхийн түүхийг бүтээлцсэн бөгөөд Их Монгол улсын үед, түүнээс хойш бараг 100-200 жил ертөнцийн талыг захирч, өөрийн соёл, ёс горимыг тулган хүлээлгэж байсан агаад Орос, Хятад, Солонгос, Перс зэрэг олон улсад монгол маягаар хөхөл (орос хэлнээ хөхөлийг “хохол” гэж байхад, хятад хэлнээ “гү-гү” гэснээр

өржээ - зохиогч), шивэргэл тавиулж (1.94-96-р тал), монгол их хаад солигдох бүрт түшмэг улсаас элч хаад нь хаан ширээнд залрах ёслолд ёс болгон ирж оролцож байсан заншлыг өнөөгийн их гүрнүүд төрийн тэргүүнээ залах үед уламжлан авч хэрэглэж байна. Мөн түүнчлэн хоёр хөршийн газар усны нэр монголчуудын анх нэрлэж тогтоосноор явж байна. Орос, Хятадад мөн өөрийн Монголд өртөөний алба XX зууны эхэн хүртэл үйлчилж, эдгээр улсад зам-шуудан харилцааг хөгжүүлж байсан нь эзэнт улсын үеийн монголчуудын л гавьяа гэлтэй.

Манай нутагт эрт үед аж төрж байсан түрэгүүдээр дамжин өнөөгийн түрэг хэлэнд 10000 монгол үг орсон бол хоёр их хөршийн хэлэнд монгол үг мөн нэлээд байдаг нь тухайн үедээ монголчууд соёл иргэншлийн хувьд хүчирхэг байсны гэрч бөгөөд нөлөө гэлтэй. Солонгос улсаас эзэн Чингисийн үе болоод хойшхи хаадын үед ч элч заран "Манай жижиг улс их улсын нөлөө нөөлөг дор амьдаръя" хэмээн удаа дараа мэдэгдэж байсан төдийгүй бүр 17-р зуун болтол Солонгост түшмэл хүний заавал үзэх гадаад хэл нь монгол хэл байсан учир өдгөө монгол-солонгос толь бичиг хийгээд монгол хэл сурах бичиг олноор хадгалагдан үлджээ. Солонгосын түүхийн чухал сурвалж бичигт тооцогддог "Корё Са"-д дурьдсаныг үзвэл, монголчууд Солонгосыг "толгой" алба бариулдаг байсан (2, 141-р тал) бөгөөд жил бүр 3000-4000 язгууртны хүүхдийг Монголд аваачин монгол айлд суулгаж элдэв ажилд зардаг байсан бололтой. Монголчууд тэдгээр хүүхдийг авч явснаар нэгэн ёсны Солонгосыг Монголоос хамааралтай байлгах барьцаа болгож ийн солонгос ноёдыг дуулгавартай байлгах арга хийн эл улсад нөлөөгөө 100 гаруй жил хадгалсан түүхтэй. Хэдийгээр очигсдыг ямар хугацаанд Монголд барьцаалдаг байсан нь тодорхойгүй ч ямар болов ч уг хүүхдүүд эх нутагтаа буцаж очсон хойноо монгол үг хэллэгийг солонгос хэлнээ нэвтрүүлсэн төдийгүй зарим монгол зан дадлыг нэвтрүүлсэн ажээ. Өөр бас нэг сонин зүйл хэмээвээс Солонгосын найман ван монголчуудтай ураг барилдаж байсан баримт бас түүхнээ үлджээ. Солонгос вангуудтай ураг барилдсан монгол хатад мөн монгол ёс заншлыг вангийн ордонд нэвтрүүлсэн нь дамжиггүй. Тэр үеэс л солонгос эхнэр нүүрэндээ оо энгэсэг тавих болж, гутал нь хүртэл монгол маягийн этгэр хоншоортой болж, хоолны нэр төрөл дотор "шөлөн тан" орох болжээ. Ноёд нь монголчуудад харцага шувуугаар алба барих болсноор "харчига" гэдэг үг, мөн жороо морь унаж хэрэглэх болсноор "жороо мар" хэмээсэн хэллэг тус тус солонгос хэлнээ буй болсон байна. Түүнчлэн энэ үеэс эхлэн солонгосчууд хоол ундны сав суулгад мөнгөн болон төмөр аяга, савх хэрэглэх болсон бололтой.

Ер нь монголчууд эрт үеэс бөө мөргөл шүтэж ирсэн хэдий ч их эзэнт улсын нийслэл Хархорум хотноо бурхны шашны, лалын хийгээд загалмайтны сүм дуган байгуулж, аливаа шашныг ялгаварлан гадуурхалгүй хүлцэнгүй хандаж байжээ. Тухайн үеийн Хархорум хотод нийт 12 шашны сүм дуган, хийд оршин байж, зарим алтан ургийнхан хүртэл загалмайтны, күнзийн, лалын шашныг шүтэж байснаас үзэхүл өнөө үед ардчилсан улс гүрнүүдийн төрийг шашнаас ангид байлгаж, аливаа шашинг үл ялгаварладаг “tolerant” буюу хүлцэнгүй хандах зарчимтай адил мэт санагдана. Монголчууд хэдийгээр түүхэндээ олон бичиг үсэг авч хэрэглэж байсан ч анх согд арамейчуудаас авсан бичгийг улам боловсронгуй болгон өөрийн монгол бичиг болгон улмаар манж нарт зээлдүүлэх хүртэл хэмжээнд хүргэж хөгжүүлсэн болно.

Нүүдэлчин монголчууд дэлхийн олон улсаас түрүүнд Их Чингис хааны үеэс гадаад гүрэнд элч томилохдоо алт, мөнгө, хүрэл, модон зэрэг зэрэг яаралтай хийгээд чухалчлалын зэргээсээ хамааран хэрэглэж эхэлсэн нь хожим хойно Европод хэрэглэх болсон паспортын эхлэл байсныг энд онцлох хэрэгтэй буюу. Өнөөгийн манай монголчуудын дунд нүүдлийн аж төрөх ёсыг шүүмжилж, улсын хэтийн ирээдүй суурин амьдралд шилжсэнээр сая хөгжих мэтээр бичигсэд мэр сэр байдаг нь нүүдлийн соёл иргэншлээ ойлгодоггүйгээс үүдэлтэй хэмээн миний бие үздэг болно. Нүүдлийн соёл иргэншил өнөөг хүртэл хөгжин ирэхдээ сонгодог хэлбэртээ орсон бөгөөд хүн ардын амь зуулга нь байгаль цаг агаараа даган өөрчлөгдөх хүртэл цаашид ч оршино хэмээн үзнэм.

Нүүдлийн соёл иргэншил нь өдөр тутмын амьдралд илүү мэдрэгддэг бөгөөд тухайлбал малаа маллаж байгаа арга ажиллагаа, билчээр нутгаа сэлгэж нүүдэл хийж буй байр байдал, ахмад настандаа хандах хандлага, эцэг эхээ ачлах, үр хүүхдээ элбэрэх хайр халамж, олгох хүмүүжил, хүн хүндээ хандах харьцаа, мэнд мэдэх соёл, уул усаа тахиx, баяр наадам хийх, сар шинээр золгохуй ёсон, сүү цагаан идээгээ бэлтгэх, мал төхөөрч гаргах, гэр засал, эсгий хийх, унаа хөсгөө янзлах арга ухаан, бэр гуйх, хүргэн орох, хурим найр хийх, хүн нутаглуулах заншил, малаа тойглох, билгэдэл хийх, морь мал шинжихүй, мал тамгалж им тавих уламжлал, цацал өргөх, ерөөл айлдах, бөх хийгээд хурдан морь цоллох урлаг зэрэг олон зүйл үйл хөдөлгөөн, зан үйл, заншлаас Монголын нүүдлийн соёлыг мэдэж авна. Мөн түүний баялаг аман зохиол, уран яруу хэл, ялангуяа мал аж ахуйтай холбоотой үг хэллэг үгийн санд их бөгөөд өөр аль ч хэлэнд байдаггүйн нэг жишээ л гэхэд монгол хэлний үгийн санд морины өнгө зүсэм илэрхийлэх 500-үг байдаг, мөн монгол цагаан идээний нэр төрлийг гадаад хэлнээ буулгахад тухайн хэлний үг

хүрэлцдэггүй болно. Түүнчлэн монголчуудын зохиосон түүх шастир, уран зохиол ялангуяа “Монголын нууц товчоо”, “Гэсэр”, “Жангар” зэрэг нь дэлхийн оюуны сангийн үнэт өвд ордгийг хэлэхэд хангалттай.

Суурин хийгээд нүүдлийн соёл иргэншлийн ялгаа

Суурин соёл иргэншилтэй улсын тоо нүүдлийн соёл иргэншилтэй улсаас их байдаг. Суурин соёл иргэншилтэй улс нь эрхэлж буй үндсэн аж ахуйгаасаа шалтгаалан эрт үеэс өнөөг хүртэл ихэвчлэн жилдээ ганц ургац авч аж төрдөг. Тиймээс тэдний хувьд бүтэн жилийн хөдөлмөрийн үр шимээ хүртэж ургац хураах цаг нь жинхэнэ баяр байдаг. Сайн ургац нь газар тариаланчдын дараа жилийн амьдралын түвшинг тодорхойлдог бол нүүдлийн мал аж ахуй эрхэлсэн улсууд жилдээ нэг улиралд-хавартаа мал төллөх үеэр тарчиг байвч, дараа дараагийн жилдээ ам тосдох сүргийнхээ тоог нэмэхээр баярлаж байдаг. Монгол хэлний хавар гэсэн үг ховор гэдэг үгнээс гаралтай хэмээн хэл шинжээчид үздэг нь ортой буюу.

Суурин газар аль эрт үеэс хамтын хүчээр амин зуулга үр тариагаа авахын тулд ус шуудуу суваг далан юугаан татаж ирсэн тул төв рүү тэмүүлдэг бол нүүдэлчид айл саахалтаараа буюу тармаг амьдарч ирсэн тул төвөөс зугтах хүчинд баригддаг юм. Үүнээс үүдэн амьдрах ухаан, сэтгэлгээ нь асар их ялгаатай байдаг. Тухайлбал, суурин соёл иргэншилтнүүд амьдрахын тулд хамтын хүч хөдөлмөрийг шүтэн, хот суурин байгуулж, төрийн аль нэг байгууллагад хүчтэй баригддаг бол нүүдэлчид “малгай хаана тавина, тэнд манайх” гэсэн сэтгэлгээгээр аливаад хандан эрх чөлөөт анархи амьдралыг юунаас ч илүүд үзэн, хэн нэгний захиргаанд орохыг үл дурлан, тархай бие даасан байдлаар амьдардаг. Өөрөөр хэлбэл, суурин газрынхан хамтаар аливааг цогцлон босгохын төлөө байхул, нүүдэлчид бүтээхээсээ илүү үрэн таран хийхэд гаршсан байдаг буюу. Жишээлэн хэлбээс, суурин соёл иргэншилтнүүд хойч үедээ олон хот шилтгээн босгон эд өлгийн зүйлсээ өвлүүлэн үлдээсэн байхад нүүдэлчид амьдралын хэв маягаасаа шалтгаалан эд өлгийн зүйлсээ материаллаг байдлаар бус, зөвхөн аман зохиолоор болон зан заншлаараа дамжуулан өвлүүлж иржээ. Суурин газарт аливаад хамтаар шийдэл гаргадаг бол нүүдэлчид аливаа асуудлыг бие даан шийддэг тул илүү индивидуалист, бие хүний хувьд илүү төлөвшсөн байх ажээ. Ийм ч учраас эрс тэс хоёр өөр сэтгэлгээтэй байдаг. Дүгнэн өгүүлэхэд суурин соёл иргэншлийн өв баялаг нүдэнд үзэгдэх нь их байхад, нүүдлийнх болохоор ил үзэгдэх нь бага ч алсуур дотоод байдлаараа

илэрхийлэгддэг. Өмнө өгүүлсэнчлэн нүүдлийн соёлыг дотоод орчинд нь байж хэсэг хугацаанд хамт амьдарч, хэлийг нь мэдэж, зан заншлыг нь сайн ухаарч байж мэдрэн сая өвөрмөц байдлыг нь ойлгоно.

Манай улсыг тойрсон суурин соёл иргэншил

Манай улсыг тойрсон соёл иргэншил нь бүгд суурин газрынх болно. Тодотгон өгүүлбэл, Орос, Хятад, Өрнөд, Япон, Солонгосын соёл иргэншил юм. Орос болон Хятадын соёл иргэншил аль эрт үеэс хаяа дэрлэн оршсоор ирсэн ч манай Монголын нүүдлийн соёл иргэншилд нөлөөлөн уусгаж чадаагүй нь амьдралын хэв маяг, аж ахуйн чиглэл өөрөөс болсон гэж тайлбарлаж болно. Мөн амьдралыг үзэх үзэл, сэтгэлгээ, философи ухаан эрс ялгаатай байдагтай холбоотой. Тухайлбал, монгол хүн “ууланд гарах хэцүү, харин буух амар” гэж байхад хятад хүн “ууланд гарах амархан, харин буух хэцүү” хэмээх ганцхан хэллэгээс үзэхэд бид хоорондоо ямар их ялгаатай болохыг ухаарч болно.

Өөр нэгэн сонин зүйлийг миний бие түүхч хүний хувьд олж харсан юм. 1989 онд Монгол-Японы хамтарсан “Гурван голын төсөл” гэгчээр их Чингис хааныг нутаглуулсан газрыг хайх хээрийн судалгааны ажил эхлэхийн өмнө миний бие “Чингис хааныг нутаглуулсан тухай хятад сурвалжийн мэдээ” гэсэн сэдвээр хоёр улсын эрдэмтдийн хамтарсан хуралд илтгэл тавих болж хятад, монгол дундат зууны үеийн сурвалж бичиг дэх дээрх сэдэвтэй холбоотой баримт сурвалжаас үзэхэд Их хааныг манай сурвалж бичигт “Алтай ханы ард, Хэнтий хааны өвөрт Их өтөг нэрт газар онголов” гэж бичсэн байхад хятад сурвалж бичигт “Тэмүүжиний шарил Онон голын хөвөөнд уул усаар хүрээлүүлсэн газарт буй” гэсэн байсныг олж үзээд илтгэлдээ “монголчууд Их хааныг нутаглуулсан газрыг уулаар баримжаалан бичсэн байхад хятад сурвалжид газар тариалан эрхэлдэг улс учраас гол усаар баримжаалсан байна” хэмээсэнд (2,97-98-р тал) хуралд оролцож байсан суурин соёлт японы эрдэмтэд их олзуурхан “үнэхээр тариачин ард газрын баримжааг уулаар бус үр тариа тарьж болох устай газраар баримжаална” гэгцгээж билээ. Манай өмнөд хөрш Хятад улс 3 мянга 500 жилийн төрийн түүхтэй, харин хойт хөрш Орос улс “Киевийн Орос”-оор он тоолол хийвэл 1000-хан жилийн төрийн түүхтэй тул манай Монгол улсаас залуу улс юм.

Эл хоёр улс өөр шашин шүтлэгтэй, ондоо арьстан, зан аалийн талаар өөр өөр. Өдгөө дэлхийн, бүсийн их гүрнүүд болсон хоёр хөрш маань дэлхийн суурин соёл иргэншилд өөр өөрийн үнэтэй дорвитой хувь нэмрийг оруулсан. Тухайлбал, Орос улс

шинжлэх ухааны нээлт гаргасан олон эрдэмтэд, мөн олон сонгодог зохиолч, яруу найрагч, хөгжмийн зохиолч, анхны сансрын нисгэгч, чадварлаг тамирчид, ялангуяа алдартай шатарчид төрүүлсэн байхад Хятад улс анх цаас, луужин, шаазан зэргийг бүтээсэн байдаг. Аль аль нь Монголын эрхшээлд хэдэн зуун жил байсан тул монголчуудаас эмээсээр иржээ. Иймээс Монголын хэрэгт хөндлөнгөөс ямагт оролцож монголчуудын дунд яс хаяж, эв нэгдэлгүй болгон улмаар тархай бутархай байлгах сонирхолтой байсаар ирснийг түүх гэрчилнэ.

Өнөөгийн Монгол улс ардчиллыг сонгож нээлттэй болсноос хойш хоёр хөршийн суурин соёл иргэншлээс гадна Өрнөдийн соёл иргэншил нэвтэрч байна. Энэхүү соёл иргэншлийн гол үнэт зүйлс болох ардчилал, хүний эрхийг дээдлэх зарчим, улс төрийн тогтолцоонд парламентын засаглалтай, олон намын тогтолцоо тогтсон, Ром-Германы эрх зүйн тогтолцоотой болсон, жинхэнэ сонгох сонгогдох эрх чөлөө хэрэгжсэн, эдийн засаг өрнөдийнхний анхлан замнасан чөлөөт зах зээлийн системд шилжсэн, улс төржсөн нийгмийн шинжлэх ухаан судлал хийгээд сургалтын чиг өөрчлөгдөж эхэлсэн, боловсролд америкийн кредит үнэлгээний зарчим хэрэглэх болсон, урлагийн салбарт шоу гэгч түрэн нэвтэрсэн, шашин шүтлэгийг чөлөөтэй болгосноор Загалмайтны шашны олон урсгал дэлгэрч олон сүм дуган байгуулагдсан, орос хэлийг 70 жил дэлгэрүүлж байснаа англи хэл сурах хөдөлгөөн идэвхтэй өрнөсөн, хэвлэл мэдээлэл үзэл суртлын хяналтаас ангижирсан, иргэд чөлөөтэй гадаадад зорчих болсон, хувийн өмчийг гадуурхаж байсныг халсан, интернеттэй холбогдох зэргээр дэлхийн техник технологийн хөгжил дэвшлийн ололтоос эзэмшиж эхэлсэн зэргээр өнөөдөр Монголд тусгалаа олж байна.

Азийн суурин соёл иргэншилтэй бусад орнууд, тухайлбал Япон хийгээд Өмнөт Солонгосын нөлөө Монгол улсад нэвтэрч байна. Эл хоёр улс нь Хятадын соёлын нөлөөнд үлэмж автсаныг бичиг үсэг, шашин шүтлэг, төрт ёсны уламжлал, кунзын суртал, одөр тутмын амьдралын хэв маяг, ертөнцийг үзэх үзэл, зан үйл, хоол унд, гэр сууц зэргээс харж болно. Гэсэн хэдий ч Хятадаас авсан зүйлсээ өөрийн байгаль, цаг агаар, хүн ард, үндэсний сэтгэлгээндээ зохицуулан өөрчилсөн юм. Түүнчлэн эл хоёр улс *homogeneous* буюу нэг үндэстнээс бүрдсэнээрээ Монгол улстай ижил ажээ. Япон улс монголчуудтай анхлан Хубилай хааны үед, дараа нь XX зууны эхнээс дахин түүхийн эрхээр холбогдсон бөгөөд Халх голын тулалдаанаар хоорондоо дайтаж, дэлхийн 2-р дайны төгсгөлөөр манай улс Зөвлөлтийн Армийн хамт Квантуны армитай тулалдан ялсан агаад улмаар 1972 онд манай хоёр улс хоорондоо дипломат харилцаа тогтоосон байна.

Одоо хоёр улсын харилцаа иж бүрэн түншлэл тогтоохоор хөгжиж байна. Япон улс нь Монгол улсад ардчилал тогтсоноос хойш хамгийн том хандивлагч улс болсон бөгөөд харилцаа, хамтын ажиллагаа бүх салбарт идэвхтэй хөгжиж байна. Хоёр улсын харилцаа улам бүр хөгжихөд, мөн эх орноо сурталчлахад манай залуучууд дуучин Оюунтүлхүүр болон сумо бөх Батбаяр, Цэвэгням, Дагвадорж, Дашням нар ард түмний элч болон чамгүй хувь нэмэр оруулж байна. Япон улс нь дэлхийн Монгол судлалыг хөгжүүлэхэд эрдэмтдээрээ дамжуулан үлэмж ихийг хийсэн орон мөн. Хэдийгээр япончууд арлын сэтгэхүйтэй ч эх газрын Монгол хоёрын хооронд харилцаа хөгжихөд таатай хэд хэдэн хүчин зүйл байна. Тухайлбал нэг арьстан, нэг цул үндэстнээс бүтсэн улсууд, зарим талаараа угсаа гарал нэгтэй гэгддэг, япон, монгол хэл нэг хэлний аймаг учир харилцан хоёр биенийхээ хэлийг сурахад амар хялбар, мөн бидний зан заншилд зарим ижил төстэй зүйл байдаг зэрэг буюу.

Монгол, Солонгос хоёр улс эрт үеэс харилцаа холбоотой байж иржээ. Сүүлийн арваад жил Монголын дорнод хэсэгт хоёр орны эрдэмтэд түүх археологи, антропологийн өргөн судалгаа хийсний дүнд манай хоёр үндэстэн гарал үүсэл нэгтэйг тогтоож өглөө. Мөн солонгос хэл монгол хэлтэй нэг аймаг, гарал нэгтэй үг олон байдаг нь улам бүр ойртоход сайхан хөрс болж байна. Түүнчлэн Солонгосын ёс заншилд ижил төстэй зүйл олон байхыг миний бие тэнд уригдан очиж судалгааны ажил хийхдээ олж ажигласан бөлгөө. Тухайлбал, ахмадаа хүндэтгэж байгаа нь, хүнд юм өгөхдөө заавал баруун гараараа өгдөг, залуу хүн ахмадынхаа дэргэд элдвийг ярьдаггүй, хэрэвхүйеэ өөрийг нь магтахул ичингүйрч нүүрээ буруулдаг гэх мэт болно. БНСУ-д манайд байдагтай ижил төстэй хүн чулуу хийгээд яст мэлхий чулуун баримал, мөн яст мэлхийн нуруун дээр бараг 4,5 метр өндөр монгол, манж, хятад хэлээр бичсэн хөшөө байдаг нь хоёр улс өнгөрсөн түүхэндээ нарийн хэлхээ холбоотой явж ирснийг илтгэнэ. Солонгос хүмүүс өөрсдөө ч монгол, солонгос гарал нэгтэй хэмээн ярьдаг агаад монгол хүнд Зүүн хойд Азийн бусад улс үндэстнээс илүү дотно ханддаг ба өдгөө БНСУ-д ойролцоогоор 15 мянган монголчуудыг ажиллуулж байгаа бөгөөд тэнд буй монгол ажилчид сар бүр ойролцоогоор 5-10 мян. ам. доллар ар гэртээ гуйвуулдаг гэсэн судалгаа байдаг. Мөн манайд ирж бизнес эрхлэн амьдарч буй БНСУ-ын иргэдийн тоо өссөөр байна.

Монгол улс 1990 онд хуучин Азийн социалист чиг баримжаатай улсуудаас хамгийн түрүүнд БНСУ-тай дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр улсын харилцаа улам бүр ойртон нягтарсаар байна. Хоёр улсын хооронд дээд хэмжээний айлчлалууд

тогтмолжсон. БНСУ-ын түрүүчийн ерөнхийлөгч Ким Дэ Жун Монгол улсад 1999 оны зун айлчлах үедээ хоёр Солонгосыг нэгтгэх дөрвөн талын яриа хэлцэлд хоёр Солонгос, АНУ, БНХАУ-ын дараагаар Монгол улсыг 5 дахь улс болгон оролцуулж болох юм гэсэн нь их л олзуурхууштай мэдэгдэл байсан билээ. Үнэхээр манай улс хоёр Солонгос улстай харилцаа сайн тул Солонгосын хойгийн асуудалд идэвхтэй оролцох боломжтой юм.

Монголын нүүдлийн соёл иргэнийн хэтийн төлөв

Өнгөрсөн зууны сүүлийн хагаст Монголын нүүдлийн соёл иргэншил дэлхийн хөгжлийн чиг хандлагыг даган асар их өөрчлөгдөж хүн амын нэлээд хэсэг хотжилтын үйл явцыг даган суурин амьдралд орон үндсэн аж ахуй болох мал аж ахуйгаас гадна газар тариалан эрхлэх болсны дээр хот суурин газруудад аж үйлдвэржүүлэлт явагдаж олон үйлдвэр байгуулагдан Монгол улс хөдөө аж ахуй - аж үйлдвэрийн улс болсон билээ. Өдгөө Монголын хүн амын бараг 40 хувь нь хот суурин газар амьдарч байгаа бөгөөд ийн хоёр өөр амьдралын хэв маягтай монголчууд буй болсноор боловсрол хүмүүжил хийгээд сэтгэлгээний хувьд асар их ялгаатай болсон ажгуу. Энэ XXI зууны даяаршлын үйл явцад монголчууд өргөн хамрагдан орвоос манайд суурин соёл иргэншлийн нөлөө нэмэгдэж улмаар суурин амьдрал илүү газар авах магадлал их байна.

Манай монгол туургатны нэг хэсэг болох Орос улсад амьдардаг буриад нар бараг зуун жилийн тэртээгээс суурин амьдралд орж оросжсон бол нөгөө нэг хэсэг болох өвөрлөгч нарын дийлэнх хэсэг нь хятаджиж зөвхөн бүр алслагдсан малжих оронд аж төрдөг цөөн монголчууд уламжлалт нүүдлийн соёл иргэншлээ хадгалан үлдэж байгаа ч билчээрээ хуваан торон хашаа татан шавар байшинд суух болов. Иймээс монгол туургатны жинхэнэ нүүдлийн соёл иргэншлийн гал голомт өдгөө манай улсад байна гэж хэлэх үндэслэлтэй. Манай Монголын нүүдлийн соёл иргэншил биеэ даасан цогц бүрдэл юм. Цаашид суурин соёлын иргэншлийн нөлөөнд бага багаар орох авч түүнд уусахгүй бөгөөд харин ч түүний дэвшилтэт үнэт зүйлсээс өөрийн соёл иргэншлийн онцлог, нийгэм-үндэстний өвөрмөц сэтгэлгээнд тохируулан уусган зохицуулах замаар өвлөн авбаас улам сайн хэмээн үзнэ.

Ашигласан ном, хэвлэл

1. Ж.Баясах. Записки южносунских дипломатов как источники по истории и этнографии монголов начала XIII века., УБ, 1997
2. Ж.Баясах. Дорно дахины судлалын зарим асуудал., УБ, 1995